

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн нэр шилжүүлэхээр хүсэлт гаргасан 2 /хоёр/ иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэн хавсралтаар баталгаажуулсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэн баталгаажуулсан 2013 оны А/105 дугаар захирамжийн Тотал-Инж ХХК, 2012 оны А/99 дугаар захирамжийн Д.Баатарзориг нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрх шилжүүлэн авсан иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газрын албанд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ж.Лхагвасүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ